



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 3/21

Эмзэлтолгой

Г Хэлний бодлогын зөвлөлийн сумын салбар зөвлөлийг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 35 дугаар зүйлийн 35.1.17, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн "Салбар зөвлөл байгуулах тухай" 03 дугаар тогтоолын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн сумын салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга	Сумын Засаг дарга
Нарийн бичгийн дарга	Насан туршийн нэгжийн багш
Гишүүд	Нийгмийн бодлогын мэргэжилтэн ЕБС-ийн дунд, ахлах боловсролын менежер ЕБС-ийн бага боловсролын менежер ЕБС-ийн монгол хэлний секцийн ахлагч Цэцэрлэгийн арга зүйч Соёлын төвийн номын санч Эрүүл мэндийн төвийн архив, бичиг хэргийн ажилтан

2.Монгол хэлний талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 10/03 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.МӨНХЖАРГАЛ



642401035